



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 15/02

Пионер толгой

Хоршоо хөгжүүлэх сангаас зээл  
олгох хугацааг товлон дахин  
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 15 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хоршоо дэмжих сангийн төсөл хүлээн авах хугацааг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 1 сарын хугацаагаар товлосугай..
2. Төсөл сонгон шалгаруулахдаа журмын дагуу болзол, шалгуур хангасан хоршоо, шаардлагад нийцэх хоршоо байхгүй тохиолдолд шаардлага хангасан аж ахуйн нэгж, иргэнд зээлийг олгохыг зөвшөөрсүгэй.
3. “Хоршоо дэмжих сан”-гийн журмын хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагааны үр дүнг жилийн эцсийн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Гантулга), ЗДТГ-ын дарга (Р.Гантулга) нарт үүрэг болгосугай.

ДАРГА *Ч.Эрдэнэ-Очир* Ч.ЭРДЭНЭ-ОЧИР



642301003